

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 4-Р САРЫН ТОЙМ МЭДЭЭ


2014 оны 4 дүгээр сард нийт 22 удаагийн үнэт “Баянхайрхан” /100.0 сая төгрөг/, “Таван цаасны арилжаагаар 79 компанийн 11.7 сая толгой” /74.7 сая төгрөг/ ХК-ийн үнэт ширхэг хувьцаа арилжиж, нийт 3.2 тэрбум цааснууд идэвхтэй арилжигджээ. төгрөгийн гүйлгээ хийгджээ.

Хувьцааны арилжааны үнийн дүн өмнөх сараас 2.3 тэрбум төгрөгөөр буюу 3.7 дахин, өнгөрсөн оны мөн үеэс 1.5 тэрбум төгрөгөөр буюу 1.9 дахин тус тус өсчээ.

Арилжигдсан хувьцааны тоо ширхэг өмнөх сараас 10.9 сая ширхэгээр буюу 14.1 дахин, өнгөрсөн оны мөн үеэс 7.4 сая ширхэгээр буюу 2.7 дахин өссөн байна.

Хувьцааны арилжаа

“Монголиа девелопмент ресорсес” ХК-ийн 1.0 сая ширхэг, “Ремикон” ХК-ийн 255.9 мянган ширхэг, “Баянхайрхан” ХК-ийн 200.0 мянган ширхэг, “Силикат” ХК-ийн 119.3 мянган ширхэг, “Женко түр бюро” ХК-ийн 88.7 мянган ширхэг, “Гермес центр” ХК-ийн 87.3 мянган ширхэг хувьцааг арилжсан нь тоо ширхэгээр хамгийн их арилжигдсан үнэт цааснууд юм. Арилжааны үнийн дүнгээр,



“Дархан нэхий” /688.1 сая төгрөг/, “Монголиа девелопмент ресорсес” /601.2 сая төгрөг/, “Шарын гол” /239.5 сая төгрөг/,

Анхдагч зах зээлийн арилжаа

2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр “Мерекс” компанийн олон нийтэд санал болгосон 26.0 сая ширхэг хувьцааг анхдагч зах зээлд амжилттай арилжлаа.

Багцын арилжаа

Тайлант хугацаанд 4 удаа багцын арилжаа явагдаж, “Баянхайрхан” ХК-ийн 92.72 хувийг 100.0 сая төгрөгөөр, “Хялганат” ХК-ийн 17.25 хувийг 9.8 сая төгрөгөөр “Монголиа девелопмент ресорсес” ХК-ийн 7.27 хувийг 600.0 сая төгрөгөөр, “Дархан нэхий” ХК-ийн 3.60 хувийг 665.5 сая төгрөгөөр тус тус арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 43.63 хувь болж байна.

Энэ сард өдөрт дунджаар 143.3 сая төгрөгийн гүйлгээ хийж, 532.1 мянган ширхэг хувьцаа арилжсан байна.

Бондын арилжаа

Энэ сард Засгийн газрын болон Компанийн бондын арилжаа явагдаагүй байна.

Үнэт цаасны ханш


Нийт 79 үнэт цаас арилжигдсанаас өмнөх сарын сүүлийн өдрийн хаалтын ханштай харьцуулахад 34 үнэт цаасны ханш өсч, 37 үнэт цаасны ханш буурч, 8 үнэт цаасны ханш тогтвортой байлаа.

TOP-20 индекс

TOP-20 индекс 15,522.61 нэгж байгаа нь өмнөх сараас 781.41 нэгжээр буюу 4.8%-иар буурч, өмнөх оны мөн үеэс 1523.64 нэгжээр буюу 10.8%-иар өссөн байна.

TOP-20 индексийн энэ сарын хамгийн дээд үзүүлэлт нь 16,092.61 нэгж, доод үзүүлэлт нь 15,498.43 нэгж, дундаж үзүүлэлт нь 15,775.84 нэгж байна.

TOP-20 индексийн сагсыг бүрдүүлж байгаа Монголиа девелопмент ресорсес (13.63%), Монголын цахилгаан холбоо (5.42%), Багануур (5%), АПУ (8.54%) зэрэг ХК-ийн үнэт цаасны ханш өмнөх сараас тус тус буурсан байна.



Зах зээлийн үнэлгээ

Зах зээлийн нийт үнэлгээ 1 их наяд 599.6 тэрбум төгрөг болж өмнөх сараас 40.8 тэрбум төгрөгөөр буюу 2.5 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 279.1 тэрбум төгрөгөөр буюу 21.1 хувиар өссөн байна.

Зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй компанид АПУ, Таван толгой, Шивээ овоо, Багануур, Шарын гол, Бэрх уул, Говь, УБ-БҮК, Монгол секьюритиес, МЦХ зэрэг компаниуд орж байна.

Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компанийн үнэлгээ нийт зах зээлийн үнэлгээний 85.9 хувь нь болж байна. Зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй компани нь “АПУ” ХК бөгөөд зах зээлийн үнэлгээ нь 278.58 тэрбум төгрөг болсон байна.

Брокер дилерийн компаниуд

Тухайн сард үнийн дүнгээр хамгийн их үнэт цаас арилжсан брокер дилерийн компаниудын тоонд “Стандарт инвестмент” ХХК /1.78 тэрбум төгрөг/ “БиДиСек” ХК /1.55 тэрбум төгрөг/, “Дэлгэрхангай секьюритис” ХХК /1.36 тэрбум төгрөг/, “Евразиа капитал монголиа” ХХК /603.8 сая төгрөг/, “Нэйшнл сэкьюритис” ХХК /204.6 сая төгрөг/, тус тус орсон байна.

